

## МОНГОЛБАНКИНД

### “АРИГ БАНК” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН П.МӨНХ-ЭРДЭНИЙН АЖЛЫН ТАЙЛАН

2021 оны 05 сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

“Ариг банк” ХХК дээр Монголбанкны Бүрэн эрхт төлөөлөгч бүтэн нэг жилийн хугацаанд ажиллаад холбогдох шаардлагыг хангасан гэж үзэн 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр Б.Ариужаргалыг томилж, мөн банкны ТУЗ-ийн 5 гишүүдийг томилсноор түүний үүрэг дуусгавар болсон билээ.

НЭГ. “Ариг банк” ХХК-ийн ТУЗ-ийн хурал 2021 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 10.00 цагт цахим хэлбэрээр, 100 хувийн ирцтэйгээр зохион байгуулагдсан ба хурлаар дараах асуудлуудыг хэлэлцсэн. Үүнд:

1. Ариг банкны 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж, дүгнэлт гаргах,
2. Аудитын компани сонгох эрхийг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчид олгох,
3. ТУЗ-ийн даргыг сонгох,
4. ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг сонгох,
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдууах,
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлыг батлах.

Энэхүү хурлаас дараах шийдвэрүүд хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүдийн 100 хувийн саналаар гарсан. Үүнд:

1. “Ариг банк” ХХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг хангалттай гэж дүгнэсэн ба хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оруулан батлуулахаар шийдвэрлэсэн.
2. Аудитын компани сонгох эрхийг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчид нөхөн олгож шийдвэрлэлээ. Одоо ажиллаж байгаа Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч нь 2020 оны турш ажиллаагүй тул эрх ашгийн зөрчил үгүй байсан гэж үзсэн.
3. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгчээр М.Өлзийбатыг томилсон.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр Ариг банкны төв байранд зарлан хуралдуулахаар шийдвэрлэсэн.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Үүнд:
  - ✧ “Ариг банк” ХХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах.
  - ✧ “Ариг банк” ХХК-ийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох.

ТУЗ-ийн хурлаар дор дурдсан асуудлыг хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүдийн 80 хувийн саналаар баталсан. Үүнд:

1. “Ариг банк” ХХК-ийн ТУЗ-ийн даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн П.Мөнх-Эрдэнэ намайг сонгосон болно.

Дээрх асуудлуудыг хэлэлцэн баталснаар ТУЗ-ийн хурал дууссан бөгөөд энэхүү хуралд миний зүгээс зарчмын зөрүүтэй дараах товчхон байр суурийг илэрхийлсэн болно.

... “Ариг банк” ХХК-ийн өнөөгийн зээл, санхүүгий байдал хүнд байна. Мөн хувьцаа эзэмшигч нар маргаантай асуудалтай байгаа зэргээс шалтгаалан ТУЗ-ийн даргыг “Номин холдинг” ХХК, Ш.Баярсайхан захиралтай ойр ажилладаг, мөн Гүцэтгэх удирдлагад өдөр тутамдаа туслан дэмжиж ажиллах боломжтой хүнээр сонгож ажиллуулах нь зүйтэй байна. Миний бие тусдаа ажилтай тул өдөр тутам удирдлагаар ханган ажиллах тал дээр дутагдалтай байх талтай ..... гэсэн саналаа хэлсэн.

ХОЁР. “Ариг банк” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 10.00 цагт Банкны төв байранд эхлүүлэхээр ТУЗ-ын дарга миний бие П.Мөнх-Эрдэнэ, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч М.Өлзийбат, “Улаанбаатар импэкс” ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал И.Галбуян, “Ариг банк” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Ариужаргал, Тооллогын комиссын гишүүн н.Сонинцэцэг, Монголбанкны хянагч н.Мөнх-Эрдэнэ нар хүрэлцэн ирсэн. Харин Хувьцаа эзэмшигч “Дэмсанхүүгийн нэгдэл” ХХК-ийн төлөөлөл ирээгүйн улмаас хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц бүрдээгүй. “Дэмсанхүүгийн нэгдэл” ХХК-ийн төлөөлөл хуралд хүрэлцэн ирээгүй нь Ковид-19 цар тахалын тархалттай холбогдуулан Засгийн газраас хөл хорио тогтоосон нөхцөл байдалтай холбоотой хүндэтгэн үзэх шалтгаантай байна гэж үзээд ТУЗ-ийн хурлыг яаралтай зарлан хуралдуулж, Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хойшлуулан товлох, мөн дахин хөл хорио сунгагдсан үед хойшуулсан хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулах, хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулах журам боловсруулах шаардлагатай гэж үзсэн болно.

ГУРАВ. “Ариг банк” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц бүрдээгүй асуудалтай холбогдуулан ТУЗ-ийн дарга миний бие 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 17.00 цагт ТУЗ-ийн хурлыг яаралтай зарлан хуралдуулсан.

Уг ТУЗ-ийн хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсэн. Үүнд:

1. Хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулах журмыг батлах.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хойшлуулан товлох зэрэг асуудлуудыг хэлэлцсэн.

ТУЗ-ийн хурал 100 хувийн ирцтэй хуралдаж, хуралд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар дараах асуудлуудыг шийдвэрлэсэн.

1. “Ариг банк” ХХК-ийн ТУЗ-ийн хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулах журам болон “Ариг банк” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулах журмыг тус тус баталсан.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хойшлуулан Засгийн газраас тогтоосон хөл хорионы хугацаа дууссаны дараа буюу 2021оны 05 дугаар сарын 10-ны

өдрийн 10.00 цагт Ариг банкны төв байранд хуралдуулахаар шийдвэрлэсэн. Хэрэв хөл хорио дахин сунгагдсан тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулах бэлтгэл ажлыг хангахыг нарийн бичгийн дарга М.Өлзийбатад даалгалаа.

Хурлаар зарчмын зөрүүтэй байр суурь, асуудал байгаагүй болно.

ТАЙЛАН ГАРГАСАН:

“Ариг банк” ХХК-ийн ТУЗ-ийн

хараат бус гишүүн

П.Мөнх-Эрдэнэ

2021 оны 05 дугаар сарын 06-ны өдөр